



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 11/121

Улаанбаатар хот

Халдварт өвчнийг тандах журам
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2; Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг үндэслэн, Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

- Халдварт өвчнийг тандах журмыг нэгдүгээр, Тэргүүлэх чиглэлийн халдварт өвчний жагсаалт, Тандалтын тогтолцоогоор тандах хам шинж, халдварт өвчний тохиолдлын тодорхойлолтыг хоёрдугаар, Халдварт өвчний тандалтын 7 хоногийн мэдээний хүснэгтийг гуравдугаар, Халдварт өвчний тандалтын 7 хоногийн нэгдсэн мэдээний хүснэгтийг дөрөвдүгээр, Үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах хуудсыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Халдварт өвчнийг тандах журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Н.Цогбадрах), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
- Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл Мэндийн Сайдын 2010 оны 152 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т даалгасугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



080452



Эрүүл мэндийн сайдын 2016 оны
11. сарын 04 өдрийн 11:00 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧНИЙГ ТАНДАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон журмын дагуу олныг хамарсан дэгдэлт, нийгмийн эрүүлмэндийн онцгой байдал үүсгэж болзошгүй, Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн шаардлагын дагуу мэдээлэх болон Монгол улсад зонхилон бүртгэгддэг, тэргүүлэх чиглэлийн халдварт өвчин, хамшинж, үйл явдлыг илрүүлэн бүртгэж, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийж, бүх шатны эрүүл мэндийн байгууллага, шийдвэр гаргагчдыг эргэн мэдээллээр хангах, хариу арга хэмжээг нотолгоонд тулгуурлан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий тогтолцоог халдварт өвчний тандалтын тогтолцоо гэнэ.

1.2 Халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэн, эрсдлийн үнэлгээ хийж, нотолгоонд тулгуурласан хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь халдварт өвчний тандалтын тогтолцооны зорилго бөгөөд энэхүү тогтолцооны үйл ажиллагааг зохион байгуулахад Халдварт өвчний тандах журам /цаашид “журам” гэх/-ыг баримтлана.

Хоёр. Тандалтын тогтолцооны нэгжийн үйл ажиллагааны чиглэл

2.1 Халдварт өвчний тандалтын нэгж нь өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд байна.

2.2 Энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан тохиолдлын тодорхойлолтод тохирсон халдварт өвчний хам шинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлыг тандана.

2.3 Сэжиглэсэн, илрүүлсэн халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол болон онош батлагдсан тохиолдлыг мэдээлэхдээ Эрүүл мэндийн статистикийн мэдээ, мэдээллийн холбогдох журмаар баталсан мэдээлэх хуудсыг ашиглана.

2.4 Үйл явдлын мэдээллийн эх үүсвэр нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд, хүн ам, сайн дурын идэвхтэн, нийгмийн тусlamж үйлчилгээний байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн албан ба албан бус мэдээ, дам яриа, шар мэдээнүүд байна.

2.5 Үйл явдлыг эрэмбэлэн, баталгаажуулж, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийсний дараа хариу арга хэмжээг зохион байгуулна.

2.6 Даваа гарагаас Ням гарагийг дуусталх долоо хоногийн хугацааг мэдээлэл цуглуулах “Эпидемиологийн долоо хоног” гэнэ.

2.7 Тухайн эпидемиологийн долоо хоногт халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдал бүртгэгдээгүй бол “тэг” мэдээлэл өгнө.

2.8 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар (ЭМГ) нь харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд халдварт өвчний тандалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэргэжлийн арга зүйгээр хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах ажлыг гүйцэтгэнэ.

2.9 Халдварт өвчний тандалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах ажлыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ) гүйцэтгэнэ.

2.10 Зоонозын халдварт өвчний тандалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах ажлыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ) гүйцэтгэнэ.

Гурав. Мэдээлэл цуглуулах

3.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр үзлэг, оношилгоо хийж байхдаа тохиолдлын тодорхойлолтод тохирсон халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлыг илрүүлж, бүртгэн өөрийн байгууллагын тархвар судлаач эмч эсвэл асуудал хариуцсан мэргэжилтэнд тухайн ажлын өдөрт багтаан мэдээлнэ.

3.2 Тандалтын тогтолцоогоор мэдээлэх халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлыг хоёр, хорин дөрвөн цагт яаралтай мэдээлэх болон эпидемиологийн 7 хоногоор нэгтгэн мэдээлэх гэж ангилна.

3.3 Хоёр цагийн дотор мэдээлэх

3.3.1 Үзлэг, оношилгоогоор илрүүлсэн дараах халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг 2 цагийн дотор мэдээлнэ. Үүнд:

- тарваган тахал;
- шинэ болон сэргэн тархах вирусийн халдвар (шинэ дэд хэвшинжээр үүсгэгдсэн хүний томуу, хүний коронавирусийн халдвар, Зика вирусийн халдвар гм);
- амьсгалын цочмог халтай хамшинж (АЦХаХ);
- зэрлэг омгийн полиовирусээр үүсгэгдсэн полиомиелит;
- цусархаг чичрэг;
- урвах тахал;
- ховор, өмнө нь бүртгэгдэж байгаагүй үйл явдал.

3.3.2 Оношийг сэжиглэсэн, илрүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь анхны мэдээллийг 1 цагийн дотор өөрийн байгууллагын тархвар судлагч /тархвар судлалын асуудал хариуцсан эмч болон шууд харьяалах удирдах албан тушаалтанд утсаар мэдээлнэ.

3.3.3 Холбогдох албан тушаалтан нь мэдээлэл авсан даруй аймаг нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэнд утсаар мэдээлнэ.

3.3.4 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн нь анхны мэдээллийг хүлээн авснаас хойш 30 минутын дотор ЗӨСҮТ-д 70282853 тоот утас, eop@nczd.gov.mn цахим шуудангаар, ХӨСҮТ-д 11-451158 тоот утас, eop@nccd.gov.mn цахим шуудангаар давхар мэдээлнэ.

3.3.5 ХӨСҮТ, ЗӨСҮТ нь анхны мэдээллийг хүлээж авснаас хойш 30 минутын дотор ЭМЯ-ны Шуурхай удирдлагын төвд 51-261629 тоот утсаар, eoc@moh.gov.mn, eochealth2014@gmail.com цахим шуудангаар давхар мэдээлнэ.

3.4 Хорин дөрвөн цагийн дотор мэдээлэх

3.4.1 Үзлэг, оношилгоогоор илрүүлсэн дараах халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлыг **24** цагийн дотор мэдээлнэ. Үүнд:

3.4.2 Эмнэлзүйн хамшинж бүхий өвчний сэжигтэй **нэг** тохиолдол:

- цочмог сул саажилт;
- цочмог халууралт, тууралттай (дэгдэлтийн бус үед) хамшинж.

3.4.3 Халдварт өвчний сэжигтэй **нэг** тохиолдол:

- менингококт халдвар;
- боом;
- галзуу;
- сахуу;
- хөхүүл ханиад.

3.4.4 Нэг голомтод **гурваас дээш** тохиолдол:

- хоолны хордлогот халдвар;
- эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвар

3.4.5 Оношийг сэжиглэсэн, илрүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь анхны мэдээллийг **6** цагийн дотор өөрийн байгууллагын тархвар судлагч /тархвар судлалын асуудал хариуцсан эмч болон шууд харьялах удирдах албан тушаалтанд утсаар мэдээлнэ.

3.4.6 Холбогдох албан тушаалтан нь мэдээлэл авснаас хойш **6** цагийн дотор аймаг нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэнд утсаар, цахимаар мэдээлнэ.

3.4.7 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн нь анхны мэдээллийг хүлээн авснаас хойш **6** цагийн дотор ЗӨСҮТ-д 70282853 тоот утас, eop@nczd.gov.mn цахим шуудангаар, ХӨСҮТ-д 11-451158 тоот утас, eop@nccd.gov.mn цахим шуудангаар давхар мэдээлнэ.

3.4.8 ХӨСҮТ, ЗӨСҮТ нь анхны мэдээллийг хүлээж авснаас хойш **6** цагийн дотор ЭМЯ-ны Шуурхай удирдлагын төвд 51-261629 тоот утас, eoc@moh.gov.mn, eochealth2014@gmail.com цахим шуудангаар давхар мэдээлнэ.

3.5 Долоо хоногт мэдээлэх

3.5.1 Үзлэг, оношилгоогоор илрүүлсэн дараах халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлыг эпидемиологийн **7** хоногоор “Халдварт өвчний тандалтын **7** хоногийн мэдээ” (Хавсралт 3)-нд **нэгтгэн, долоо хоног тутам** мэдээлнэ. Үүнд:

- цочмог цусархаг суулгалт;
- гахай хавдар;
- салхин цэцэг;

- энтеровируст халдварт /гар хөл амны өвчин/;
- олон эмэнд тэсвэртэй нянгийн халдварт.

3.6 Дамжуулагчаар дамжих халдварт өвчнийг улиралчлалын үед нь холбогдох заавар, журмын дагуу тандаж, 7 хоног тутам мэдээлэл цуглуулна.

3.7 Тархвар судлагч /тархвар судлалын асуудал хариуцсан эмч долоо хоногоор болон хоёр, хорин дөрвөн цагийн дотор мэдээлэх халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлыг эпидемиологийн 7 хоногоор “Халдварт өвчний тандалтын 7 хоногийн мэдээ” (Хавсралт 3), “Үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах хуудас” (Хавсралт 5)-т тус тус нэгтгэн, **даваа гараг бүр** аймаг нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэнд утсаар, цахимаар хүргүүлнэ.

3.8 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн нь харьялах эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн мэдээг “Халдварт өвчний тандалтын 7 хоногийн нэгдсэн мэдээ” (Хавсралт 4), “Үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах хуудас” (Хавсралт 5)-т тус тус нэгтгэн **мягмар гараг бүр** eop@nczd.gov.mn хаягаар ЗӨСҮТ-д, eop@nccd.gov.mn хаягаар ХӨСҮТ-д цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.9 Тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тархвар судлагч эмч халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлыг “Халдварт өвчний тандалтын 7 хоногийн мэдээ” (Хавсралт 3), “Үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах хуудас” (Хавсралт 5)-т тус тус нэгтгэн **мягмар гараг бүр** eop@nczd.gov.mn хаягаар ЗӨСҮТ-д, eop@nccd.gov.mn хаягаар ХӨСҮТ-д цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.10 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн нь харьяа нутаг дэвсгэрийн, ХӨСҮТ, ЗӨСҮТ нь улсын хэмжээний тандалтын мэдээнд дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлэл бэлтгэн, **лхагва гараг** бүрээрүүл мэндийн байгууллагуудад тус тус хүргүүлнэ. Эргэн мэдээлэл нь зөвхөн албан хэрэгцээнд зориулагдана.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэх үүрэг

4.1 Эмчийн гүйцэтгэх үүрэг

4.1.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь тус журмын 2.2; 2.3; 3.1; 3.3.2; 3.4.5-д заасан үүргийг гүйцэтгэнэ.

4.1.2 Сэжиглэсэн, илрүүлж, бүртгэсэн тохиолдлоос лабораторийн шинжилгээнд шаардлагатай сорьцыг цуглуулж, холбогдох лабораторит хүргүүлнэ.

4.1.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь дэгдэлтийн хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнд ажиллана.

4.2 Эрүүл мэндийн байгууллагын тархвар судлагч/тархвар судлалын асуудал хариуцсан эмчийн гүйцэтгэх үүрэг

4.2.1 Эрүүл мэндийн байгууллагын тархвар судлагч эмч эсвэл тархвар судлалын асуудал хариуцсан эмч нь тус журмын 2.7; 3.3.3; 3.4.6; 3.6-д заасан үүргийг гүйцэтгэнэ.

4.2.2 Сэжиглэсэн, илрүүлж, бүртгэсэн тохиолдлоос сорьц цуглуулах, хадгалах, холбогдох лабораторид хүргүүлэх ажлыг зохион байгуулж, шинжилгээний дүнг хүлээн авч, удирдах албан тушаалтанд мэдээлнэ.

4.2.3 Нэн яаралтай мэдээлэх халдварт өвчний тохиолдол, үйл явдлын мэдээллийг авсан даруй хариу арга хэмжээний багийг удирдан голомтод ажиллах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт тархахаас сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.

4.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг

4.3.1 Тус журмын 2.7; 3.3.4; 3.4.7; 3.7; 3.8-д заасан үүргийг гүйцэтгэнэ.

4.3.2 Харьяа эрүүл мэндийн байгууллагаас тандалтын долоо хоногийн мэдээг цаг хугацаандаа, бүрэн гүйцэт ирүүлсэн байдалд хяналт тавина.

4.3.3 Сорьц цуглуулах, хадгалах, холбогдох лабораторид хүргүүлсэн эсэхэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийнэ.

4.3.4 Халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн үед судалгааны багийг удирдах ба “Дэгдэлтийн үеийн судалгаа хийх үе шат”-ын дагуу судалгааг хийж, дүгнэлтийг эрсдлийн үнэлгээнд ашиглана.

4.3.5 Эрсдлийн үнэлгээний дүнд үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөж, халдварт өвчин бүртгэгдсэн үед мөрдөх журам, зааврын дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3.6 Харьяалах эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг халдварт өвчнийг тандах, дэгдэлтийн үеийн судалгаа хийх, хариу арга хэмжээг зохион байгуулах, дасгал сургуулилт хийхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.3.7 Тандалтын тэргүүлэх чиглэлийн болон зонхилон бүртгэгддэг халдварт өвчний босго үзүүлэлт, олон жилийн төлөв байдлыг өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд тооцож, дэгдэлтийг баталгаажуулах, бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөхөд ашиглана.

4.3.8 Халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлынтоон мэдээ, дэгдэлтийн судалгаа, эрсдлийн үнэлгээний дүнг цаасан болон цахим хэлбэрээр; долоо хоногийн эргэн мэдээллийг цахим хэлбэрээр мэдээллийн сан үүсгэн хадгална.

4.3.9 Эрсдлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны багийн бүрэлдэхүүнд орж ажиллана.

4.3.10 Халдварт өвчний дэгдэлтийн үед цагийн байдлын мэдээлэл өөрчлөгдсөн бол тухай бүрт цахим шуудангаар, дэгдэлтийн судалгааны эцсийн тайланг судалгаа дууссанаас хойш 14 хоногийн дотор ЭМЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-далбан бичгээр хүргүүлнэ.

4.3.11 Тандалтын тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй бусад халдварт өвчний сар бүрийн статистикийн тоон мэдээнд харьцуулсан дүн шинжилгээ хийж, дэгдэлтийг илрүүлж, хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлнэ.

4.3.12 Халдварт өвчний тандалтын тогтолцооны үйл ажиллагаа, мэдээ мэдээллийн бүрэн гүйцэт байдалд хяналт-шинжилгээ, дэмжклэгт хяналт хийж, тасралтгүй сургалтыг зохион байгуулна.

4.4 ХӨСҮТ, ЗӨСҮТ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

4.4.1 Тус журмын 2.8; 2.9; 3.3.5; 3.4.8; 3.8 -д заасан үүргийг гүйцэтгэнэ.

4.4.2 Аймаг, нийслэлийн ЭМГ, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс ирүүлсэн халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлын мэдээг цаг хугацаандаа, бүрэн гүйцэт ирүүлсэн байдалд хяналт тавина.

4.4.3 Халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн үед шаардлагатай тохиолдолд судалгааны багийг томилон, “Дэгдэлтийн үеийн судалгаа хийх үе шат”-ын дагуу судалгааг хийж, дүгнэлтийг эрсдлийн үнэлгээнд ашиглана.

4.4.4 Эрсдлийн үнэлгээний дүнд үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөж, тухайн халдварт өвчин бүртгэгдсэн үед мөрдөх журам, зааврын дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4.5 Эрсдлийн хамтарсан үнэлгээгээр халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн онцгой үйл явдлын эрсдлийн зэрэглэл нь өндөр, маш өндөр гэж үнэлгэдсэн бол Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлж, баг томилон, хариу арга хэмжээг тухай орон нутгийн холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.4.6 Халдварт өвчний дэгдэлтийн үед мэдээлэл өөрчлөгдсөн бол тухай бүрт цахим шуудангаар, дэгдэлтийн судалгааны эцсийн тайланг судалгаа дууссанаас хойш 14 хоногийн дотор ЭМЯ-д албан бичгээр хүргүүлнэ.

4.4.7 Аймаг, нийслэлийн ЭМГ, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд халдварт өвчнийг тандах, дэгдэлийн үеийн судалгаа хийх, дасгал, сургуулилт, хариу арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.4.8 Тандалтын тэргүүлэх чиглэлийн болон зонхилон бүртгэгддэг халдварт өвчний босго үзүүлэлт, олон жилийн хандлага, төлөв байдлыг улсын хэмжээнд тооцон, дэгдэлтийг баталгаажуулах, бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөхөд ашиглана.

4.4.9 Халдварт өвчний дэгдэлтэд хийсэн судалгаа, хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний тайланг хагас жилээр багцлан хөндлөнгийн багаар эргэмж үнэлгээ хийлгэж, дүгнэлтийг 14 хоногийн дотор ЭМЯ-д албан бичгээр хүргүүлнэ.

4.4.10 Халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдол, үйл явдлынтоон мэдээ, дэгдэлтийн судалгаа, эрсдлийн үнэлгээний дүнг цаасан болон цахим хэлбэрээр; долоо хоногийн эргэн мэдээллийг цахим хэлбэрээр мэдээллийн сан үсгэн хадгална.

4.4.11 Эрсдлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны багийг журмын дагуу томилж ажиллуулах, салбарын болон салбар хоорондын оролцоо, хамтын ажиллагааг хангаж ажиллана.

4.4.12 Тандалтын тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй бусад халдварт өвчний сар бүрийн статистикийн тоон мэдээнд харьцуулсан дүн шинжилгээ хийж, дэгдэлтийг илрүүлж, хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлнэ.

Тав. Бичил амь судлалын лабораторийн гүйцэтгэх үүрэг

5.1 Эрүүл мэндийн байгууллагын лабораторийн гүйцэтгэх үүрэг

5.1.1 Тохиолдлын түвшин нь босго үзүүлэлтээс дээш гарсан, дэгдэлт, кластер хэлбэрээр бүртгэгдсэн халдварт өвчний сэжигтэй тохиолдол, хамшинж, ховор, өмнө нь бүртгэгдэж байгаагүй үйл явдлын үед эхний тохиолдлуудаас цуглуулж, хүргүүлсэн сорьцод үүсгэгчийг тодорхойлон, дэгдэлтийг баталгаажуулна.

5.1.2 Цуглуулсан сорьцыг хүлээн авснаас хойш урьдчилсан хариуг 24 цагийн дотор, эцсийн хариуг 72 цагийн дотор эмчлэгч эмч, тархвар судлагч / тархвар судлалын асуудал хариуцсан эмч, ЭМГ-ын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэнд мэдээлнэ.

5.1.3 “Бичил биетний эрсдлийн бүлгийн жагсаалт”-д орсон, өмнө нь бүртгэгдэж байгаагүй, ховор вирус, нян илэрсэн тохиолдолд 24 цагийн дотор ХӨСҮТ-д еор@nccd.gov.mn, ЗӨСҮТ-деор@nczd.gov.mn хаягаар тус тус мэдээлнэ.

5.1.4 Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, оношлуур, шил сав, био-аюулгүй тоног төхөөрөмж, сорьц хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай хэрэгсэл, нөөцийн бэлэн байдлыг хангана.

5.1.5 Сорьц цуглуулалт, тээвэрлэлт, хадгалалт, шинжилгээний баталгаажилтын байдалд дүгнэлт хийж, эргэн мэдээлнэ.

5.1.6 Лабораторид ялгасан нянгийн өсгөвөр болон эргэлзээтэй сорьц, үүсгэгч тодорхойгүй өвчний шинжлэгдэхүүнийг зааврын дагуу хадгалж, Үндэсний түвшний лавлагаа лабораторид илгээнэ.

5.1.7 Дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээнд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, оношлуур, шил сав, био-аюулгүй тоног төхөөрөмж, сорьц хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай хэрэгсэл, нөөцийн бэлэн байдлыг хангана.

5.2 ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн Лавлагаа лабораторийн гүйцэтгэх үүрэг

5.2.1 Тохиолдлын түвшин нь босго үзүүлэлтээс дээш гарсан, дэгдэлт, кластер хэлбэрээр бүртгэгдсэнхалдварт өвчний сэжигтэй тохиолдол, хамшинж, ховор, өмнө нь бүртгэгдэж байгаагүй үйл явдлын үед эхний тохиолдлуудаас цуглуулсан сорьцыг хүлээн авч, үүсгэгчийг тодорхойлон, дэгдэлтийг баталгаажуулна.

5.2.2 Илгээмж болон цуглуулсан сорьцыг хүлээн авснаас хойш урьдчилсан хариуг 2 цагийн дотор, эцсийн хариуг 48-72 цагийн дотор ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт, судалгааны алба, эмчлэгч эмчид тус тус мэдээлнэ.

5.2.3 Эрүүл мэндийн байгууллагуудаас хүлээн авсан сорьц, нянгийн өсгөвөрт баталгаажуулах шинжилгээ хийж, дүгнэлт гарган хариуг эргэн мэдээлнэ.

5.2.4 Ус, хоол хүнсээр дамжих халдвартын дэгдэлтийн үед тархвар зүйн холбогдолтой гэж сэжиглэж буй ус, хоол, хүнсний дээжид нян судлалын шинжилгээ хийж, шинжилгээний дүнг дэгдэлтийн судалгааны багт яаралтай мэдээлнэ.

5.2.5 “Бичил биетний эрсдлийн бүлгийн жагсаалт”-д орсон, өмнө нь бүртгэгдэж байгаагүй, ховор вирус, нян илэрсэн тохиолдолд 24 цагийн дотор ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт, судалгааны албанад тус тус мэдээлнэ.

5.2.6 Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, оношлуур, шил сав, био-аюулгүй тоног төхөөрөмж, сорьц хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай хэрэгсэл, нөөцийн бэлэн байдлыг хангана.

5.2.7 Дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээнд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, оношлуур, шил сав, био-аюулгүй тоног төхөөрөмж, сорьц хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай хэрэгсэл, нөөцийн бэлэн байдлыг хангана.

5.2.8 Сорьц цуглуулалт, тээвэрлэлт, хадгалалт, шинжилгээний баталгаажилтад дүгнэлт хийж, эргэн мэдээлнэ.

-оOo-

Эрүүл мэндийн сайдын 2016 оны
11. сарын 02. өдрийн дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

А. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

1. Шинэ болон сэргэн тархах вирусийн халдварт
2. Улаанбурхан
3. Тарваган тахал
4. Менингококт халдварт
5. Томуу, томуу төст өвчин
6. Хепатитын В вируст халдварт
7. Бoom
8. Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдварт
9. Хепатитын С вируст халдварт
10. Сахуу
11. Гахай хавдар
12. Халдварт саа /полиомиелит/
13. Галзуу
14. Улаанууд

Б. ТАНДАЛТЫН ТОГТОЛЦООГООР ТАНДАХ ХАМШИНЖ, ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТОХИОЛДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

1. Илрүүснээс хойш 2 ЦАГИЙН ДОТОР НЭН ЯАРАЛТАЙ утас, цахим шуудангаар мэдээлэх хамшинж, сэжигтэй тохиолдол

Хэн	Давтамж	Хэнд
Эмч, эмнэлгийн мэргэжилтэн		Шууд харьялагдах албан тушаалтан, тархвар судлагч эмч /тархвар судлалын асуудал хариуцсан эмч
Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	1 цагийн дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн, тархвар судлагч		ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн, тархвар судлагч
ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн холбогдох албан тушаалтан	1 цагийн дотор	Шууд харьялагдах албан тушаалтан
		ЭМЯ-ны Шуурхай удирдлагын төв

Санамж:

- Мэдээлэгдсэн сэжигтэй тохиолдлыг долоо хоног бүртандалтын мэдээнд нэгтгэж мэдээлнэ.
- Батлагдсан тохиолдлыг сар бүрийн Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр мэдээлнэ.

Тохиолдол	Тохиолдлын тодорхойлолт
1-1. Тарваган тахал	<p>Сэжигтэй тохиолдол</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн: <ul style="list-style-type: none"> - Гэнэт өндөр халуурах, чичруүдэс хүрэх, толгой хүчтэй өвдөх, үе мөч, булчингаар шархирч өвдөх, дотор эвгүйрхэх, ам цангах ба <p>Булчирхайн хэлбэрийн үед:</p>

- Тунгалгийн булчирхай хавдах, эмзэглэлтэй болох
- Барьцалдсан бэрсүү (бубон) үүсэх
Ушигны хэлбэрийн үед:
- Цустай цэртэй ханиалгах
- Цээжээр өвдөх
- Амьсгаадах зэрэг шинж тэмдгээс хоёр нь илэрсэн
БА
- Тархвар судлалын холбогдолтой:
 - Тарваган тахлын байгалийн голомтот нутагт амьдардаг
 - Тарвага зурам агнасан, арьсыг нь өвчсэн, мах өвчсэн
 - Тарваганы түүхий эд эрхтэн идсэн идсэн
 - Мэрэгч амьтны бөөс, бүүрэгт хазуулсан
 - Тарваган тахлын сэжигтэй болон өвчтэй хүнтэй цуг байсан
 - Тарваган тахлын халдвартай байж болзошгүй эд зүйлтэй харьцсан зэрэг өгүүлэлмжтэй бол;

Болзошгүй тохиолдол:

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Бичил хараад наацад мөлгөрдүү төгсгөлтэй хоёр туйл нь тод будагдсан, зууван хэлбэртэй савханцар харагдах ба
 - Дархан туяаралт бичил харуураар нянг тойрсон тод ногоон өнгөтэй өвөрмөц гэрэлтэт харагдах эсвэл Ийлдэс судлалын шинжилгээгээр *Yersinia pestis* нянгийн эсрэгбие, эсрэг төрөгч тодорхойлогдсон бол;

Батлагдсан тохиолдол: (A20.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан.
 - Нян судлалын шинжилгээгээр тарваган тахлын үүсгэгч илэрсэн эсвэл
 - Молекул биологийн шинжилгээгээр тарваган тахлын үүсгэгчийн ген тодорхойлогдсон эсвэл
 - Ийлдэс судлалын шинжилгээгээр эсрэгбиесийн таньц 4 дахин нэмэгдсэн

1-2. Шинэ болон сэргэн тархах вирусийн халдварууд (шинэ дэд хэвшинжээр үүсгэгдсэн хүний томуу, Хүний коронавирусийн халдвар, Зика вирусийн халдвар гм)

Шинэ дэд хэвшинжээр үүсгэгдсэн хүний томуу

Сэжигтэй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Шалтгаан тодорхойгүйгээр 38°C-аас дээш цочмог халуурах ба
 - Ханиалгах, хоолой өвдөх зэрэг амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн, эсвэл
 - Шалтгаан тодорхойгүй амьсгалын халдварын улмаас нас барсан
БА

- Тархвар судлалын холбогдолтой:
 - Лабораториор батлагдсан тохиолдолтой шууд хавьтал байсан өгүүлэлмжтэй бол;

Батлагдсан тохиолдол:

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Фермент холбоот эсрэгбиесийн урвал (ФХЭБҮ), иммунохроматографи, бодит хугацааны полимеразын гинжин урвалын (RT-PCR) шинжилгээгээр томуугийн вирусийн шинэ дэд хэвшинж тодорхойлогдсон бол;

Хүний коронавирусийн халдвар

Сэжигтэй / болзошгүй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Өндөр халуурсан
 - Амьсгалын замын цочмог халдварын эмнэлзүйн шинж тэмдэг

БА

- Тархвар судлалын холбогдолтой:
 - Хүний коронавируст (MERS-CoV) халдварын лабораториор батлагдсан тохиолдолтой тархварзүйн шууд хамааралтай эсвэл
 - Ойрхи Дорнодын улс орнуудад оршин суудаг эсвэл уг халдварын тохиолдол бүртгэгдсэн улс оронд аялсан ёгуулэмжтэй

БА

- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүнгийн аль нэг гарсан:
 - Хүний коронавируст (MERS-CoV) халдварын шинжилгээ хийх боломжгүй буюу шаардлага хангаагүй сорьцонд хийсэн шинжилгээний хариу сөрөг гарсан эсвэл эргэлзээтэй; эсвэл
 - Уушгины эдийн эмгэг өөрчлөлт (уушигны хатгалгаа, амьсгалын замын цочмог дистресс хамшинж) нь эмнэлзүй, рентген, гистопатологиор батлагдсан бол;

Батлагдсан тохиолдол:

- Сэжигтэй /Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
- Лабораторийн шинжилгээгээр Хүний коронавирус (MERS-CoV)-ийн өвөрмөц эсрэгтөрөгч тодорхойлогдсон бол;

Зика вирусийн халдвар

Сэжигтэй / болзошгүй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Туурсан, халуурсан эсвэл халуураагүй ба дараах шинж тэмдгээс аль нэг нь илэрсэн
 - Үеэр өвдөх эсвэл
 - Булчин өвдөх эсвэл
 - Нүд улайх, үрэвсэх
- Тархвар судлалын холбогдолтой:
 - Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 2 долоо хоногийн өмнө Зика вируст халдварын өвчлөл гарч буй газар нутагт шумуулд хазуулсан эсвэл
 - Сүүлийн 4 долоо хоногийн хугацаанд Зика вируст халдвараар өвчилсөн нь батлагдсан эрэгтэй хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон эсвэл
 - Сүүлийн 4 долоо хоногийн хугацаанд Зика вируст халдварын өвчлөл гарч буй газар нутагт аялсан эрэгтэй хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон ёгуулэмжтэй

БА

- Ийлдэс судлалын шинжилгээгээр Зика вирусийн эсрэг өвөрмөц IgM илэрсэн бол;

Батлагдсан тохиолдол:

- Сэжигтэй / болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүнгийн аль нэг гарсан:
 - Эмнэлзүйн сорьцонд Зика вирусийн нуклейн хүчил илэрсэн
 - Зика вирусийн эсрэгтөрөгч илэрсэн
 - Зика вирус өсгөвөрлөгдсөн
 - Саармагжуулах урвалаар баталгаажуулахад ийлдэст Зика вирусийн эсрэг өвөрмөц IgM илэрсэн

- Хос ийлдэст Зика вирусийн эсрэг эсрэгбиенийн танц 4 дахин нэмэгдсэн бол;

1-3. Полиомиелит

Болзошгүй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Гэнэт цочмоогоор өндөр халуурах
 - Суулгах
 - Мөчид сул саажих
- Тархвар судлалын холбогдолтой:
 - Зэрлэг омгийн полиовирусээр үүсгэгдсэн полиомиелитийн тохиолдолтой хамт байсан эсвэл
 - Зэрлэг омгийн полиовирусээр үүсгэгдсэн полиомиелитийн өвчлөл бүртгэгдэж байгаа улс оронд зорчсон өгүүлэмжтэй бол;

БА

Батлагдсан тохиолдол (A80.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан
 - Эсийн өсгөвөрт полиовирус өсгөвөрлөгдсэн
 - ПГУ-аар зэрлэг омгийн полио вирусийн өвөрмөц ген илэрсэн бол;

1-4. Амьсгалын цочмог халтай хамшинж (АЦХаХ)

Сэжигтэй тохиолдол

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - 38 °C-аас дээш хэм халуурах ба
 - Ханиалгах эсвэл амьсгалахад төвөгтэй болох
- Тархвар судлалын холбогдолтой:
 - АЦХаХ-ын болзошгүй тохиолдолтой шууд хавьталд орсон
 - АЦХаХ-ын өвчлөл бүртгэгдэж буй улс оронд зорчсон
 - АЦХаХ-ын өвчлөл бүртгэгдэж буй улс оронд амьдардаг өгүүлэмжтэй бол;

Болзошгүй тохиолдол (A20.)

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Уушгины эдийн эмгэг өөрчлөлт (уушигны хатгалгаа, амьсгалын замын цочмог дистресс хамшинж) цээжний рентген зургаар батлагдсан
 - Лабораторийн шинжилгээний нэг ба хэд хэдэн аргаар АЦХаХ-ын үүсгэгч коронавирус зэрэг гарсан

Шалтгаан тодорхойгүй нас баралтын тохиолдоос авсан эдийн шинжилгээгээр амьсгалын цочмог дистресс хамшинжийн шинж тэмдэг батлагдсан бол;

1-5. Цусархаг чичрэгүүд

Сэжигтэй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Цочмог эхэлсэн
 - 40°C дээш халуурсан ба дараах шинж тэмдгийн аль нэг илэрсэн
 - Толгой хүчтэй өвдөх
 - Булчин өвдөх
 - Биен дээр толбот гүвдруут тууралт гарах, тууралт гарснаас хойш 3-4 хоногийн дараа гуужилт өгсөн
 - **Бөөлжих**
 - Суулгах
 - Гэдэс базалж өвдөх
 - Осол гэмтэлтэй холбоогүй цус алдах
 - Тромбоцитопени

БА

- Тархвар судлалын холбогдолтой:
 - Цусархаг чичрэгээр өвчилсөн хүний цус, биеийн шингэнд хүрч хавьтал болсон эсвэл
 - Цусархаг чичрэг өвчний тохиолдол бүртгэгдсэн газар нутагт аялсан эсвэл
 - Цусархаг чичрэг өвчний үүсгэгчтэй ажилладаг лабораториид ажилладаг эсвэл
 - Цусархаг чичрэг өвчинеэр өвчилсөн нь батлагдсан хүнтэй эдгэрснээс нь хойш 10 долоо хоногийн хугацаанд хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон бол;

Батлагдсан тохиолдол: (A90.- A99.)

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр цусархаг чичрэгийн аль нэг үүсгэгч батлагдсан:
 - ФХЭБҮ-ын шинжилгээгээр цусархаг чичрэгийн үүсгэгчийн эсрэгбие илэрсэн эсвэл
 - Эргэх-ПГҮ-ын шинжилгээгээр цусархаг чичрэгийн үүсгэгчийн өвөрмөц ген илэрсэн бол;

1-6. Ховор, өмнө нь бүртгэдэж байгаагүй өвчин, үйл явдал

- Шалтгаан тодорхойгүй хүний өвчлөлийн 3 ба түүнээс дээш тохиолдол
- Хүн ам, байгууллага, хамт олон, гэр бүлийн дунд гарсан шалтгаан тодорхойгүй нас баралтын 2 ба түүнээс дээш тохиолдол
- Ус, хөрс, агаарын нөлөөнөөс хүн амын өвчлөл гарсан гэх цуурхал, дам яриа
- Ус, хоол, хүнстэй холбоотой мэдээлэл, үйл явдал
- Мал, амьтны өвчлөл, үхлийн хэвийн бус байдал, шинэ, ховор үйл явдал гэх мэт

2. Илрүүснээс хойш 24 ЦАГИЙН ДОТОР утсаар, цахимаар мэдээлэх өвчин, хамшинж сэжигтэй тохиолдол

Хэн	Давтамж	Хэнд
Эмч, эмнэлгийн мэргэжилтэн		Шууд харьялгадах албан тушаалтан, тархвар судлагч/тархвар судлалын асуудал хариуцсан эмч
Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчиний асуудал хариуцсан мэргэжилтэн	12 цагийн дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчиний асуудал хариуцсан мэргэжилтэн ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн, тархвар судлагч
ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн, тархвар судлагч		Шууд харьялгадах албан тушаалтан
ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн холбогдох албан тушаалтан	12 цагийн дотор	ЭМЯ-ны Шуурхай удирдлагын төв

Санамж:

- Мэдээлгэсэн сэжигтэй тохиолдлыг долоо хоног бүр тандалтын мэдээнд нэгтгэж мэдээлнэ.
- Батлагдсан тохиолдлыг сар бүрийн Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр мэдээлнэ.

Тохиолдол

- 2-1. Менингококт халдварт

Тохиолдлын тодорхойлолт

Болзошгүй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - 38.5°C хэмээс дээш гэнэт халуурч, дараах шинж тэмдгийн аль нэг нь эсвэл олон шинж тэмдэг илэрсэн:
 - Дагз хөших
 - Унтаарах
 - Тархины хальсны үрэвслийн шинж тэмдэг илрэх эсвэл
 - Толбон эсвэл хөх ягаан өнгийн цусархаг тууралт гарах Нэг хүртэлх насны хүүхдэд:
 - Халуурах, зулай чинэрэх шинж тэмдэг илрэх БА
- Лабораторийн шинжилгээгээр тархи нугасны шингэнд дараах өөрчлөлт гарсан:
 - Цусны цагаан эсийн тоо нэмэгдсэн
 - Ургийн хэмжээ нэмэгдсэн бол;

Батлагдсан тохиолдол: (A39.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Тэжээлт орчинд *Neisseria meningitis* өсгөвөрлөгдсэн эсвэл
 - Латекс шинжилгээгээр *Neisseria meningitis* эерэг гарсан эсвэл
 - ПГҮ-аар *Neisseria meningitis* нянгийн эсрэгтөрөгч илэрсэн бол;

Сэжигтэй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Гэнэт өндөр халуурах, толгой өвдөх, чичруүдэс хүрэх, хоолонд дургүй болох
Арьсны хэлбэр :
 - Арьсан дээр гүвдүү гарч улмаар цэврүүтэнхарлаж, өвчин эмзэглэлгүй хар тав үүсэх, эргэн тойронд нь цэврүү, хаван үүссэн
Гэдэсний хэлбэр:
 - Халуурах, бөөлжих, дотор муухайрах, хоолонд дургүй болох, цустай суулгах, үжлийн шинж тэмдэг илэрсэн
Уушгины хэлбэр:
 - Амьсгалын замын вирусийн цочмог халдварын шинж тэмдгээр эхэлсэн
 - Гипокси, диспноэ(маш богино хугацаанд) илрэх
БА
- Тархвар судлалын холбогдолтой:
 - Boомын өвчний голомтот нутагт амьдардаг
 - Boомоор үхсэн малыг өвчсөн, өвчтэй малын хашаа хороо, өтөг бууцтай харьцсан эсвэл тодорхойгүй шалтгаанаар гэнэт үхсэн малыг өвчиж арьс, махыг ашигласан
 - Малын түүхий эд (арьс шир, ноос ноолуур) боловсруулдаг үйлдвэр, алтны уурхайд ажилладаг
 - Хувиараа түүхий эдийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг, боомоор тайван бус нутагт газар шорооны болон олборлох ажил эрхэлдэг
 - Мал эмнэлэг, онцгой дэглэмтэй байгууллагын лабораторит ажилладаг бол;

Болзошгүй тохиолдол:

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Наац харах аргаар тэгш төгсгөлтөй, ганц нэгээрээ эсвэл гинжилсэн байрлалтай, том савханцар харагдах
 - Дархан түяарал бичил харуурын шинжилгээнд нянг тойрсон тод ногоон өнгөтэй өвөрмөц гэрэлтэлт харагдах эсвэл
 - Ийлдэс судлалын шинжилгээгээр Bac.anthracisnangийн эсрэгбие, эсрэг төрөгч тодорхойлогдсон бол;

Батлагдсан тохиолдол: (A22.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Нян судлалын шинжилгээгээр боомын үүсгэгч Bac.anthracisilэрсэн эсвэл
 - Ийлдэс судлалын шинжилгээгээр эсрэгбиен таньц 4 дахин нэмэгдсэнэсвэл
 - ПГУ-аар боомын нянгийн ген тодорхойлогдсон

2-3. Сахуу

Болзошгүй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Амьсгалын дээд замын үрэвсэл (ларингит эсвэл фарингит эсвэл тонзиллит)-тэй ба
 - Хөөмий, залгиур, төвөнх, хамар, хоолойн салстад зузаан саарал өнгөр тогтсон бол;

Батлагдсан тохиолдол: (A36.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан:
 - Эмнэлзүйн сорьцоос *Corynebacterium diphtheria* өсгөвөрлөгдсөн эсвэл
 - Сахуугийн эсрэг хоргүйсүүр эсвэл антитоксиноор эмчлэхээс өмнө авсан хос ийлдэст *Corynebacterium diphtheria* нянгийн эсрэг эсрэгбиенийн таньц 4 дахин нэмэгдсэн бол;

Санамж: Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохириогүй боловч *Corynebacterium diphtheria* өсгөвөр илэрсэн эрүүл тээгчийг сахуугийн батлагдсан тохиолдолд тооцохгүй болно.

2-4. Галзуу

Сэжигтэй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Халуурах, чичруүдэс хүрэх, ууц нуруугаар өвдөх, гар хөл эрвэгнэх, үе үе мэдээ алдах, бие сулрах, ус, гэрэл, дуу шуугианаас айх, шүлс гоожих, дэмийрэх, таталт, саажилт үүсэх
- Тархвар судлалын холбогдолтой:
 - Галзуу өвчний голомтот нутагт амьдардаг
 - Зэрлэг болон гэрийн тэжээвэр амьтанд шүлсдүүлж, уруулж, ноцуулсан
 - Өвчилсөн мал, зэрлэг амьтдын шүлсээр бохирдлогдсон эд зүйлстэй харьцсан өгүүлээмжтэй

Болзошгүй тохиолдол:

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- Наац харах аргаар Бабеш-Негрийн биенцэр харагдах эсвэл
- Дархан туяарал бичил харуурын шинжилгээнд шар ногоон од мэт тод ногоон өнгөтэй өвөрмөц гэрэлтэж харагдах

Батлагдсан тохиолдол: (A82.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА
- ПГУ-аар галзуу өвчний үүсгэгчийн ген тодорхойлогдсон бол

2-5. Хөхүүл ханиад

Болзошгүй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Өөр бусад өвчний шалтгаангүйгээр дор хаяж хоёр долоо хоногийн турш ханиалгаж дараах шинж тэмдгүүдээс дор хаяж нэг нь илэрвэл:
 - Бүгшүүлж ханиалгах
 - Ханиалгах үедээ шуугиантай амьсгал авах
 - Ханиалгалтын төгсгөлд тунгалаг, зungaаралдсан салслаг цэр ялгарах эсвэл бөөлжсөн бол;

Батлагдсан тохиолдол: (A37.)

- Болзошгүй тохиолдлын тодорхойлолтод тохирсон
БА

		<ul style="list-style-type: none"> Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан: <ul style="list-style-type: none"> - <i>Bordetella pertussis</i> нянгийн өсгөвөр илэрсэн - ПГУ-ын шинжилгээгээр өвөрмөц нуклейн хүчил илэрсэн - Хос ийлдэст <i>Bordetella pertussis</i> нянгийн эсрэг эсрэгбиеийн таньц нэмэгдсэн бол;
2-6.	Урвах тахал	<p>Сэжигтэй тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн <ul style="list-style-type: none"> - Шалтгаангүйгээр усархаг суулгасан - Бөөлжсэн эсвэл - Усархаг суулгалтын улмаас нас барсан Тархвар судлалын холбогдолтой <ul style="list-style-type: none"> - Орон нутагт нь урвах тахлын өвчлөл бүртгэгдсэн эсвэл - Урвах тахал голомтот байдлаар бүртгэгддэг бол;
		<p>Батлагдсан тохиолдол: (A00.)</p> <ul style="list-style-type: none"> Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА <ul style="list-style-type: none"> - Лабораторийн шинжилгээгээр <i>Vibrio cholera</i> нянгийн O1 эсвэл O139 хэвшинж илэрсэн бол;
2-7.	Цочмог сул саажилт	<p>Сэжигтэй тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн <ul style="list-style-type: none"> - 15 хуртлэх насны хүүхдэд - Сул саажилт гэнэт илэрсэн бол (Гиллиан-Баррын хамшинжийг оруулна); <p>Батлагдсан тохиолдол: (A80. оношийг тодруулах зорилготой)</p> <ul style="list-style-type: none"> Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
		<ul style="list-style-type: none"> Лабораторийн шинжилгээгээр дараах үр дүн гарсан: <ul style="list-style-type: none"> - Эсийн өсгөвөрт зэрлэг омгийн полиовирус эсвэл бусад төрлийн вирус өсгөвөрлөсөн нь батлагдсан - ПГУ-ын шинжилгээгээр зэрлэг омгийн полиовирусийн болон бусад үүсгэгчийн өвөрмөц нуклейн хүчил илэрсэн бол;
2-8.	Цочмог халууралт тууралттай хамшинж	<p>Сэжигтэй тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн <ul style="list-style-type: none"> - Цочмог эхэлсэн - Халуурсан - Толбот гүвдрүүт тууралт гарсан <p>Батлагдсан тохиолдол: (ихэнх тохиолдолд B05., B06.)</p> <ul style="list-style-type: none"> Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА
		<ul style="list-style-type: none"> Лабораторийн шинжилгээгээр улаанбурханы эсрэг IgM эсвэл улаануудын эсрэг IgM болон бусад вирусийн эсрэг төрөгч илэрсэн бол;
2-9.	Хоолны хордлогот халдварт	<p>3 ба түүнээс дээш тохиолдол кластер хэлбэрээр бүртгэгдсэн (ихэнх тохиолдолд A05.)</p> <ul style="list-style-type: none"> Ус, хоол хүнсээр дамждаг өвчний эмнэлзүйн тохиолдлын тодорхойлолт нь тухайн өвөрмөц өвчинеэс хамаарна.
2-10.	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (Хийт үхжил A48. Нярайн үжил P36. багтана)	<p>2 ба түүнээс дээш тохиолдол кластер хэлбэрээр бүртгэгдсэн</p> <ul style="list-style-type: none"> Хоёр буюу түүнээс дээш үйлчлүүлэгчдийн дунд илэрсэн ижил шинж тэмдэг бүхий тохиолдлууд Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (үжил халдвар, мэс заслын дараах шархны халдвар, менингит, уушгини хатгалгаа)-ын сэжигтэй тохиолдол эсвэл нас баралт

3. Илрүүснээс хойш **ДОЛОО ХОНОГТ** цахимаар мэдээлэх өвчин, хамшинж сэжигтэй тохиолдол

<u>Хэн:</u>	<u>Давтамж</u>	<u>Хэнд</u>
Эмч, эмнэлгийн мэргэжилтэн	Ажлын өдөрт	Өөрийн байгууллагын тархвар судлагч/тархвар судлалын асуудал хариуцсан эмч
Тархвар судлагч/тархвар судлалын асуудал хариуцсан эмч	Мягмар гараг бүр	Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	Мягмар гараг бүр	ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн холбогдох алба, нэгж, тархвар судлагч

Санамж:

- Сэжигтэй тохиолдлыг долоо хоног бүр тандалтын мэдээнд нэгтгэж мэдээлнэ.
- Батлагдсан тохиолдлыг сар бүрийн Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр мэдээлнэ.

	<u>Тохиолдол</u>	<u>Тохиолдлын тодорхойлолт</u>
3-1.	Цочмог цусархаг суулгалтын хамшинж	<p>Сэжигтэй тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн: <ul style="list-style-type: none"> • Цочмогоор илэрсэн • Өтгөнд харагдахуйц цустай суулгах <p>Батлагдсан тохиолдол: (ихэнх тохиолдолд A01 .; A03. ; A04.4; A09.)</p> <ul style="list-style-type: none"> • Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА • Лабораторийн шинжилгээгээр цусархаг суулгалтын үүсгэгч (Sal. typhi, Sal.paratyphi, Shigella spp, E.coli spp, Entamoeba histolytica гм.) батлагдсан
3-2.	Гахай хавдар	<p>Сэжигтэй тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн: <ul style="list-style-type: none"> • Цочмогоор илэрсэн • Бусад өвчний шалтгаангүйгээр хоёр ба түүнээс дээш өдөр үргэлжилсэн • Нэг эсвэл хоёр талын чих орчмын шүлсний булчирхай хавдах, булчин нь чангарах • Тархвар судлалын холбоотой: <ul style="list-style-type: none"> • Лабораториор батлагдсан тохиолдолтой тархвар судлалын холбоотой өгүүлэмжтэй бол; <p>Батлагдсан тохиолдол: (B26.)</p> <ul style="list-style-type: none"> • Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА • Лабораторийн шинжилгээгээр гахай хавдрын үүсгэгч батлагдсан
3-3.	Салхин цэцэг	<p>Болзошгүй тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн: <ul style="list-style-type: none"> • Цочмогоор илэрсэн • Өөр бусад өвчний шалтгаангүйгээр толбот, гүвдрүүт, цэврүүт тууралт гарсан • Халуурсан <p>Батлагдсан тохиолдол: (B01.)</p> <ul style="list-style-type: none"> • Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон БА • Болзошгүй болон лабораториор батлагдсан тохиолдолтой тархвар судлалын шууд холбогдолтой

БА

- Лабораторийн шинжилгээгээр салхин цэцгийн үүсгэгч илэрсэн бол;

3-4. Энтеровируст халдвар (гар хөл амны өвчин)

Сэжигтэй тохиолдол:

- Эмнэлзүйн дараах шинж тэмдэг илэрсэн:
 - Цочмогоор илэрсэн
 - Гарын алга, хурууны салаа, хөлийн ул, хонго, гуяны хэсэгт толбон гүвдрүүт эсвэл цэврүүт тууралт;
 - Амны дотор хэсэг, хоолойд цэврүүт тууралт гарсан;
 - Зарим тохиолдолд шүүдэст менингит, энцефалит, цочмог сул саажилт, миокардит зэргээр хүндэрдэг.

Батлагдсан тохиолдол: (B08.)

- Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон **БА**
- Болзошгүй болон лабораториор батлагдсан тохиолдолтой тархвар судлалын шууд холбогдолтой **БА**
- Лабораторийн шинжилгээгээр энтеровирус 71 болон бусад энтеровирусийн эсрэгтөрөгч эсвэл эсрэгбие IgM илэрсэн бол;

3-5. Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвар

Лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол

- Нян судлалын шинжилгээгээр дараах “сэрэмжлүүлэх” нян илэрвэл
 - Ванкомицинд тэсвэртэй *Staphylococcus aureus* (MRSA)
 - Метициллинд тэсвэртэй *Staphylococcus aureus* (MRSA)
 - Ванкомицинд тэсвэртэй *Enterococci* (VRE),
 - Өргөтөгсэн хүрээний β-лактамаза ялгаруулдаг (ESBL) *Klebsiella pneumoniae*, *Escherichia coli*,
 - Олон эмэнд тэсвэртэй *Acinetobacter* spp.
 - Цифрофлоксацинд тэсвэртэй *Pseudomonas* spp.
 - Олон эмэнд тэсвэртэй Грам сөрөг нян (гурав болон түүнээс дээш тооны нянгийн эсрэг эмийн бүлэгт тэсвэртэй)



ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТЫН 7 ХОНГОГИЙН МЭДЭЭ

(ЭМБ-ийн тархваар судлагч нэгтгээн)

Аймаг / хот:

Сүм / Дүүрэг: _____
Хамрах отноо: _____ /-aac _____ /

Хамшинж, сэжигтэй тохиолдлын нэр²: Тохиолдлын тодорхойлолтын дагуу нөхөж бичнэ

Нийгмийн байдал 15 : 1=ажилчин, 2=малчин, 3=залбан хаагч, 4=оюутан, 5=сурагч, 6=цэцэрлэгт, 7=гэрт, 8=тэтгэвэрт, 9=ажилгүй, 10=бусад

Лабораторийн шинжилгээ		Тархвар судаллын холбогдол		Эмчилэгт хандахаас өмнө хийлгэсэн эмчилэгт		Copyli abaxacc emhe xeparitcach amnnih hsp,		Copyli abaxacc emhe xeparitcach amnnih hsp,		YpbAhnicah owo		/OvEA-10/		Maa3a3rcah xandegap		Maa3a3rcah orho ojar		OvEA-10 Baruulacah owo		OvEA-10 Baruulacah owo					
Copyli abaxaci teperin	MNH	Linnkint3a3hinn teperi ²⁹	Linnkint3a3hinn Ayh ³⁰	Linnkint3a3 Ayh rapcah	Ulnhuknichah nagaoparotion	XanAbaplii ayx	Damkix 3am ³⁴	Xaparitcach amnnih hsp	Xaparitcach amnnih hsp	KarABaprt epTceh	Emhe amnhrraa xmntrcach amnhrraa	YAAAh unpxar , xAAAh	/eApeep/	Yprazuknicah xyrhala	3Mnhrraa xexnicah orho	yaAa	xaAah unpxar , xAAAh	Copyli abaxacc emhe xeparitcach amnnih hsp,	Copyli abaxacc emhe xeparitcach amnnih hsp,	YpbAhnicah owo	/OvEA-10/	Maa3a3rcah xandegap	Maa3a3rcah orho ojar	OvEA-10 Baruulacah owo	OvEA-10 Baruulacah owo
27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48				

Шинжилгээний төрөл²⁹: 1=ийлдэс судлал, 2=дархан түяарагт бичл харуул, 3=нян судлал, 4=вирус судлал, 5=молекул биологи.

ЧИЖИЛГЭЭНИЙ ДҮН ^{30.} 1=эөрөг, 2=сөөрөг, 3=эргэлзээтэй;

Халдварын эх **Чүрхай**³³ 1=xvh, 2=мал(терлийг бичнэ vv), 3=амьтан (төрлийг бичнэ vv), 4=тогтоодоогүй;

Дамжих зам³⁴: 1=ахийн/шиуд хавьтэл, 2=агаар/дусал, 3=дам халдвэр, 4=чусаар, 5=yч/хоол хүнсээр, 6=тодорхойгүй.

21



ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТЫН 7 ХОНГОЙН НЭГДСЭН МЭДЭЭ

(ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн нэгтгэнэ)

Аймаг /хот:

Хамрах отноо: _____ /-аас _____ /

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
Зунаа Аярап	Perencptniih Aяrap	Хам шинж цахилт3н	Хам шинж хэд	Openiih хэд	Xvic	Akupih xar	Cym Aypar	Bar / Xopoо	Fзaap / Banp fяamak	Toot	Vrachpi Aяrap	Hinrmnni h Ganraar ¹⁵	Змажн3rt xahacah orho	Хас gаpcah 3cax	Emmavlyi hароо /har minh	Tnm gor amjashat orho	Tnm gor amjashat xabtcah 3cax	Хас gаpcah 3cax (tnm vryi)	Tnm gor amjashat xabtcah orhoо	Tnm gor amjashat xabtcah 3cax (tnm vryi)	Emmэлэүийн мэдэээлэл / гол илэрсэн з шинж тэмгийг бичнэ	Mnajpcan orhoо har	Mnajpcan orhoо har	Mnajpcan orhoо har	Mnajpcan orhoо har

Хамшинааж, сэжигтэй тохиолдлын нэр² : Тохиолдлын тодорхойлолтын датуу нөхөж бичнэ
Нийгмийн байдал¹⁵ : 1= ажилчин, 2=малчин, 3=салбан хаагч, 4=оюутан, 5=сурагч, 6=цэцэрлэгт, 7=гэрт, 8=тэтгэвэрт, 9=ажилгүй, 10=бусад

Шинжилгээний төрөл²⁹: 1=ийлдэс судлал, 2=дархан түяаралт бичил харуул, 3=нян судлал, 4=вирус судлал, 5=молекул биологи; Шинжилгээний дун³⁰: 1=ээрэг, 2=сөрөг, 3=эрэлжээтэй; Халдварын эх уурхай³¹: 1=хүн, 2=мал (терлийг бичнэ үү), 3=амьтан (терлийг бичнэ үү), 4=тогтоогдоогүй; Гамжих зам³²: 1=ахуйчиншиуд хавийтай, 2=агаар/дусал, 3=дам халдвар, 4=чусаар, 5=үсч/хоол хүнсээр, 6=тодорхойгүй.

Мэдээлсэн аймаг, хот ⁴². Эрүүл мэндийн статистикийн мэдээнд хэрэглэдэг кодыг ашиглана.
Мэдээлсэн сум, дүүрэг ⁴³.
Мэдээлсэн байгууллага ⁴⁴.
Мэдээлсэн хэлбэр ⁴⁵. 1=үтсаар, 2=цахил шуудангаар;

